

**ЯАМДЫН 2002 ОНЫ IV САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

/2002.03.26.-2002.04.25./

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ

Эдийн засаг, нийгмийг 2001 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтийг яамд, байгууллагуудын ирүүлсэн материалд үндэслэн 2001 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэв.

- ◆ Үндсэн чиглэлд нийт хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн 281 арга хэмжээнээс 205 арга хэмжээ буюу 72.9 хувь нь бүрэн биелсэн, 76 арга хэмжээ буюу 27.1 хувь нь хэрэгжиж байгаа гэсэн тооцоо гарсан. Эдийн засаг, төсөв санхүүг эрүүлжүүлэх талаар дэвшүүлсэн зорилт бүрэн биелэсэн бөгөөд макроэдийн засгийн тэнцвэрт тогтвортой байдал бүрэн хангагдсан явдал 2001 оны эдийн засгийн гол ололт боллоо.
- ◆ Макроэдийн засгийн тогтвортой байдлыг хангаж төсвийн алдагдлыг бууруулан, тулгамдсан өр төлбөрийг 2 дахин бууруулж, дотоодын үйлдвэрлэл сэргэн, аж үйлдвэр дүнгээрээ 4,8 хувь өсөв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Төсвийн зарлага санхүүжилтийн норм нормативийн үндэслэлийг сайжруулах талаар тавьсан зорилтыг хангах, төсөвт байгууллагын удирдлага санхүүжилтийн эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх, төсвийн эрх захирагчдын эрхийг өргөтгөх, бодлоготой уялдуулан төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгсэл, хэрэглээний зүйлийн стандарт, орон нутгийн удирдлагын хувьсах зардлын нормативыг төслөөр шинээр боловсруулав.

Төсвийн санхүүжилтийн, түүний дотор төрийн алба, төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, удирдлагын зардлыг зохистой түвшинд хямдруулах, татварын шинэ орчин бүрдүүлэх шаардлагатай байгааг харгалзан “Улсын төсвийн зардлын удирдлагыг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх ажлын чиглэлийг боловсруулан, Төсвийн удирдлагыг боловсронгуй болгох, бүтцийн шинэчлэл хийх ажлын асуудлаар Засгийн газрын ажлын хэсэг байгуулан ажиллав.

- ❖ Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн 2002 оны I улирлын гүйцэтгэлийг гаргахад, улсын төвлөрсөн төсөвт 69,1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөгтэйгөөс 72,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөг 3,5 тэрбум төгрөг буюу 5,1 хувиар давуулж биелүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 10,1 тэрбум төгрөгөөр илүү байна. Улсын төвлөрсөн төсвөөс тайлант хугацаанд 107,7 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлэх төлөвлөгөөтэйгөөс 82,8 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13,3 тэрбум төгрөгөөр илүү байна. Улсын төвлөрсөн төсвөөс цалинд 7,5 тэрбум төгрөг зарцуулахаас 7,7 тэрбум төгрөг, НД-ийн шимтгэлийн зардалд 1,3 тэрбум төгрөг зарцуулахаас 1,7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 15,5 тэрбум төгрөгийн татаас олгохоос 15,7 тэрбум төгрөг тус тус олгосны дээр тэтгэврийн нөхөн олговорт 652,9 сая төгрөг, халамжийн тэтгэвэрт 4480,3 тэрбум төгрөг, иргэдийн эрүүл мэндийн даатгалын хураамжийн төр хариуцах зардалд 1000,0 сая төгрөг, өндөр насны тэтгэврийн санд төрөөс олгох эх үүсвэрт 6000,0 сая төгрөгийн 100,0 хувь олголоо.
- ❖ ҮТЕГ-тай хамтран төсөвт байгууллагуудын банкин дахь харилцах дансны тооллого хий дүнг ЗГ-т танилцуулахаар оруулаад байна. Тооллогын дүнгээр 14 банкинд төрийн оролцоотой 107 компанийн 232 данс, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 298 газрын 553 данс, Засгийн газрын 38 сангийн 52 данс, 3788 төсөвт байгууллагын 6582 данс, төрийн өмчит 158 газрын 344 данс бүгд 4389 байгууллагын 7763 данс тоологдлоо. Тооллогын дүнг 2001 оныхтой харьцуулахад нэг данстай байгууллагын тоо 18 хувиар буурч, олон данстай байгууллагын тоо тэр хэмжээгээр өссөн байна. Өнгөрсөн онд нийт байгууллагын 21 хувь буюу 1192 байгууллага нэгээс дээш данстай байсан бол энэ онд нийт тоологдсон байгууллагын 39 хувь нь нэгээс дээш данстай байна. Өнгөрсөн онд хамгийн олон данстай байгууллага 6 данстай байсан бол энэ онд хамгийн олон данстай байгууллагын данс 16 болжээ.
- ❖ Эхний улирлын байдлаар зөвхөн аймгуудаас төвлөрсөн төсөвт 3 төрлийн орлогоор 2295,1 сая төгрөг төвлөрч улсын төвлөрсөн төсвөөс аймаг, орон нутагт 4044,2 сая төгрөг хуваарилаад байна.

ЗГ-ын хямдруулсан бондын арилжааг МХБиржээр дамжуулан 3 удаа явуулж нийт 7,5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий бондыг арилжлаа. Энэ оны IV сард буцаан төлөгдөх хуваарьтай 4,5 тэрбум төгрөгийн ЗГ-ын бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээт хугацаанд нь төллөө.

Орон нутгийн сургууль, эмнэлгийн барилгын их засварын хөрөнгийг цаашид нэмэгдүүлэх боломжийг судалж, 2003, 2004-2005 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаж шийдвэрлэх санал тооцоог үндэслэн хөдөөгийн сургууль, эмнэлгийн их засварт зарцуулах хөрөнгийн хэмжээг өмнөх оныхоос хоёр дахин нэмэгдүүлэв.

Гадаад орон, олон улсын санхүү, банкны байгууллагатай хамтарч ажилласан талаар:

АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Хөдөө орон нутгийн санхүүжилтийн төслийн зээлийн Гэрээ”, “Орон сууцны санхүүжилтийн төслийн зээлийн Гэрээ”-г Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж, улмаар УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар уг зээлийн Гэрээг соёрхон батлах тухай хуулиудыг батлав.

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкнаас олгосон “MON-P4” тоот зээлийн хүрээнд хэрэгжиж буй Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг хөгжүүлэх төслийн зөвлөх үйлчилгээний эцсийн төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, меморандум байгуулав.

Агротехимпекс ХКомпанид төслийн бус буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, сэлбэгийн үнийг бууруулах асуудлыг Гадаадын зээл, тусламжийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох танилцуулга, материалыг бэлтгэж хүргүүлээ.

Хууль тогтоомж, эрхийн актын төсөл боловсруулах, боловсронгуй болгох ажлын хүрээнд

Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон амьжиргааны доод түвшингээс хамааралгүйгээр тогтоож байх чиглэлээр “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”, “Нийгмийн даатгалаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн төлбөрийн тухай хууль”, “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”, “Нийгмийн халамжийн тухай хууль”, “Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль” хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран холбогдох хуулиудын төсөл боловсруулав.

“Арилжааны даатгалын тухай” шинэчлэн найруулсан хуулийн төсөл, “Замны хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.

Хувьчлалын бэлтгэл ажлыг хангах хүрээнд “Үнэ цэнэтэй аж ахуйн нэгж, банкыг хувьчлахад Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг томилон ажиллуулах ерөнхий журам”-ын төслийг боловсруулаад байна

Монгол Улсын Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас авсан гадаад зээл болон ЗГ-ын санхүүжилтийн хүрээнд хэрэгжих төслийн санхүүгийн тайлан гаргах журамыг баталж, мөрдүүлж эхэллээ.

ГАДААД ХЭРГИЙН ЯАМ

Стратегийн удирдлагын мэдээлэл

ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьянов Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр талууд харилцан нийлүүлж байгаа барааны гаалийн татварын түвшинг тэгшитгэх, экспортын барааны дамжин өнгөрөх төмөр замын тээврийн тарифыг багасгах талаарх хүчин чармайлтаа идэвхжүүлэхээр тохиролцов. Талууд эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны хамгийн ирээдүйтэй чиглэл, объектуудын талаар хэлэлцээд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгын үүднээс 2 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ойрын хугацаанд боловсруулахаар тохиров.

⇒ *Өмчийн шинэ хэлбэрийн үндсэн дээр хамтарсан үйлдвэр байгуулах, Монголын болон Оросын хувьчлалын төсөлд хоёр талын аж ахуйн нэгжүүдийг оролцуулах замаар харилцан хөрөнгө*

оруулалт хийхийг хөхиулэн дэмжихээр тогтов. Оросын компаниудын санхүүгийн болон материаллаг нөөцийг түшиглэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн төслүүдэд шингэрүүлсэн хий боловсруулах үйлдвэрийг Монголд байгуулах замаар ахуйн хэрэглээнд шатдаг хий ашиглах, 340 айлын сууц бүхий "Москва" орон сууцны цогцолборыг УБ-т байгуулах, "Мянганы зам" авто замын сүлжээг байгуулахад Оросын барилгын байгууллагуудыг оролцуулах, мөнгө, холимог металл олборлох, ирээдүй бүхий нүүрсний орд газрыг ашиглах мэтчилэн уул уурхайн салбарын хамтарсан төсөл хэрэгжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтын төслүүдийг хамруулж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзэв.

⇒ 1987-2001 онд явуулсан Монгол-Оросын улсын хилийн шалгалтын дүнгээр үйлдсэн баримт бичгүүдийг баталсан тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг НҮБ-д бүртгүүлэхээр тохиролцов.

Токио-Улаанбаатарын хооронд шууд нислэг хийх болсонтой холбогдуулан Япон Улсын Ерөнхий сайд асан Т.Кайфу, Ц.Хата нар, Парламентын төлөөлөгчдийн танхимын 8 гишүүн болон албаны бусад хүний хамт IV сарын 22-нд УБ-т анхны нислэгээр хүрэлцэн ирэв. Төлөөлөгчид УБ хотын Баянзүрх дүүргийн Хөх тэнгэрийн гудамжийг Токио хотын нэрэмжит болгох ёслолын ажиллагаанд оролцож, "Говь" комбинатын үйл ажиллагаатай танилцав. Мөн Ерөнхийлөгч Н.Багабандид бараалхаж, УИХ-ын дэд дарга Ж.Бямбадоржтой уулзав.

"Агаарын харилцааны тухай" Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон "Гал түймэртэй тэмцэх байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах" төслийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газрын хооронд солилцох Ноот бичигт Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Япон Улсын Элчин сайд М.Ханада нар гарын үсэг зурав.

❖ Манай хоёр орны ард түмний бие биенээ танин мэдэх, нэг нэгэндээ харилцан айлчлах боломж нөхцөлийг өргөтгөж буйгаараа Агаарын харилцааны тухай Хэлэлцээрт оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлт чухал ач холбогдолтой юм.

❖ "Гал түймэртэй тэмцэх байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах" төслийг хэрэгжүүлэх Ноот бичгийн дагуу Япон Улсын Засгийн газраас буцалтгүй тусламжийн хүрээнд манай улсын Гал түймэртэй тэмцэх газарт 739 сая иений үнийн дүн бүхий 17 нэрийн тусгай зориулалтын автомашин, иж бүрэн шуурхай холбооны хэрэгсэл, шинжээч нарын хэрэг бүртгэлийн иж бүрдэл, фото зургийн хальс угааж буулгах тоног төхөөрөмж, автомашин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний багаж хэрэгсэл зэргийг нийлүүлэх юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж БНСУ-д айлчлав. Энэ үеэр хоёр улсын хооронд иргэдийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг хангах, хууль хяналтын байгууллагуудын хооронд цогц харилцаа тогтоон цагдаа, засан хүмүүжүүлэх, хилийн шалган нэвтрүүлэх зэрэг албадын шууд хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монголд хэрэгжүүлж буй хуулийн шинэчлэлийг төгөлдөржүүлэх, Монголын хуульчдыг мэргэжлийн сургалтад хамруулах зэрэг өргөн хүрээтэй тодорхой асуудлуудыг хэлэлцэж тохиролцов.

УИХ-ын гишүүн, Монгол Улсын ШУА-ийн ерөнхийлөгч Б.Чадрраа 4 дүгээр сарын 1-3-нд Болгарт айлчлав. Айлчлалын үеэр хоёр орны ШУА-ийн хооронд 2002-2005 онд хамтран ажиллах төлөвлөгөө байгуулж гарын үсэг зурав.

Байгаль орчны сайд У.Барсболд тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д албан ёсны айлчлал хийв.

❖ Хоёр тал өөрсдийн газрын менежментийн байдлын талаар харилцан мэдээлж, хоёр яамны хооронд газар, байгалийн баялгийг ашиглах чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцож, хоёр яамны цаашдын хамтын ажиллагааны үндсэн чиглэлийг тусгасан баримт бичгийг дипломат шугамаар тохиролцож гарын үсэг зурах болов.

ХБНГУ-тай байгуулах Эрчим хүчний салбарын хөтөлбөрийн зээлийн гэрээ болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн зээлийн гэрээг УИХ-ын зохих Байнгын хороодод оруулсан бөгөөд гарын үсэг зурах нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргав. Гэрээнүүдэд 4 дүгээр сарын 23-ны өдөр гарын үсэг зурав.

Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан хооронд байгуулах Үйл ажиллагааны үндсэн чиглэлд Гадаад хэргийн дэд сайд, Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч нар гарын үсэг зурав.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг Засгийн газраар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барьж улмаар Дүрмийг соёрхон батлуулав.

- ❖ Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг 60 улс соёрхон батламжилснаар тус шүүхийг үндэслэн байгуулах эрх зүйн үндэс бүрдсэнийг зарласан ёслолын ажиллагаа 4 дүгээр сарын 11-нд Нью-Йорк хотноо НҮБ-ын төв байранд болов. ОУЭШ-ийн Ромын дүрмийг батламжилсан орны тоо 66-д хүрсэн бөгөөд тус шүүх энэ оны 7 дугаар сарын 1-нд албан ёсоор байгуулагдана.
- ❖ ОУЭШ-ийн ромын дүрэм хүчин төгөлдөр болсноор төрлөөр устгах, дайны болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг үйлдэх явдлыг таслан зогсоох, олон улсын эрх зүй, эрх зүйт төрийн зарчмыг дэлхий нийтээр дагаж мөрдөхөд чухал ач холбогдолтой түүхэн үйл явдлын эхлэлийг тавьж байгааг ёслолын хуралдаанд оролцсон төлөөлөгчид онцлон тэмдэглэв. Ёслолын ажиллагааны дараа болсон Бэлтгэл хорооны хуралдаанд Байнгын төлөөлөгч Ж. Энхсайхан үг хэлэв.

Шуурхай мэдээ

- Монгол, Оросын хилийн хамтарсан шалгалтын дүнгийн асуудлыг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэн, хууль батлуулав.
- Бүгд Найрамдах Хорват Улсаас Монгол Улсад суух Элчин сайд Желько Киричич 4 дүгээр сарын 11-нд, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсаас тус улсад суух Элчин сайд Темба Музиваке Николас Кубека 4 дүгээр сарын 18-нд тус тус Итгэмжлэх жуух бичгээ барив.
- НҮБ-ын Хүүхдийн сангаас Монгол Улсад суух суурин төлөөлөгч Ричард Прадо Гадаад хэргийн сайд Л. Эрдэнэчулуунд Итгэмжлэх захидлаа 4 дүгээр сарын 8-нд барив. Тэд Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын ажиллагааны 2002-2006 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлд удахгүй гарын үсэг зурахаар төлөвлөж байгааг сэтгэл ханамжтай тэмдэглэв. Ийнхүү НҮБ-ын Хүүхдийн сангийн УБ дахь суурин төлөөлөгчийн газрын түвшин дээшилж байгаа юм.
- Сөүл хотын Улаан Загалмайн Нийгэмлэг, БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-ны хооронд хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах тухай Проткол байгуулав. Протоколд Солонгосын талаас Монгол Улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, БНСУ-д ажиллаж, амьдарч буй монгол иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр эмчлэх, тэднийг нийгмийн хамгаалалтад авах, монгол иргэд солонгосын эмнэлгүүдэд донорын цус өгөх зэрэг нийгэм, хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагааны нэлээд тодорхой асуудал тусгагдсан болно. Тухайлбал эхний ээлжинд манайд Сөүл хотын Улаан Загалмайн Нийгэмлэгийн шугамаар 800 гаруй сая төгрөгийн дулаан шинэ хувцас тусламжаар илгээхээр тохиролцоод байна.

ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэв.

Зохиогчийн эрхийн тухай, Тоглолт ба дуу авианы бичлэгийн тухай гэрээнд нэгдэн орох тухай, Олимпийн бэлэг тэмдгийг хамгаалах тухай Найробийн гэрээнд нэгдэн орох тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанд оруулахад бэлэн болгоод байна. Шүүхийн тухай хуулийн төслийг боловсруулав.

Доорх хуулийн төслүүдэд санал өгөв. Үүнд:

- Мансууралтай тэмцэх тухай
- УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай
- Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Гэрээ соёрхон батлах тухай
- Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай

- Ромын дүрэмд нэгдэн орох тухай
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай
- Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Мэдээлэл, мэдээжүүлэлт, мэдээллийг хамгаалах тухай, Малын даатгалын тухай, Гадаадын зээл тусламжийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдааг зохицуулах тухай, Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалд санал өгч, тэдгээрийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулав.

УИХ-ын тогтоолын 1, Засгийн газрын тогтоолын 20, Ерөнхий сайдын захирамжийн 2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 3 төсөлд тус тус санал бэлтгэж хүргүүлэв.

БНСУ-ын Хууль зүйн сайд Сунг Жон Ху, Хууль тогтоомжийн удирдах газрын дарга Пак Чан Жү, Хууль зүйн яамны Сургалт, судалгааны хүрээлэнгийн ерөнхийлөгч Ким Хак Жа нарыг Монгол Улсад айлчлахыг албан ёсоор урьсан урилга, Монгол Улсын ХЗДХЯ, БНСУ-ын Хууль зүйн яам хооронд 2002-2004 онд хамтран ажиллах тухай протоколын төслийг боловсруулав.

Монгол Улсын ХЗДХЯ, ОХУ-ын Хууль зүйн яам хооронд 2002-2003 онд хамтран ажиллах протоколын төслийг боловсруулж, 4 сарын 12-нд протоколд гарын үсэг зурав.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны үйл ажиллагаатай холбоотой “Мэдээлэл харилцан солилцох журам”, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн бүтэц, дүрэм, орон тоо, албан тушаалын зэрэглэлийг боловсруулж, батлуулав.

Импортын согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлыг улсын хэмжээнд шалгах ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэх ажлыг хийж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ГХУСАЗөвлөлийн ажлын алба хамтран БСШУЯ, Хилийн цэргийг удирдах газарт сахилга, дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх талаар зохиож буй ажлыг шалгаж, дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Архидан согтуурахтай тэмцэх бодлого зохицуулалтын зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэв.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ

“Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ан агнуурын тухай”, “Ойн тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.

“Агаар бохирдуулсны төлбөрийн тухай”, “Газрын хэвлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудийн төслийг боловсруулав.

“Химийн бодисыг аюултай шинж чанараар нь ангилсан жагсаалт”, “Хүн амьтны бие махбодид үзүүлдэг сонгомол сөрөг нөлөөллөөр нь химийн бодисыг ангилсан жагсаалт”-уудыг эцэслэн боловсруулж, улсын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх зөвшөөрлийг авав.

“Загасны аж ахуй эрхлэх журам”-ын төсөл, Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах эдийн засгийн урамшууллын тогтолцоо болон байгалийн нөөц баялгийг эзэмшүүлэх, өмчлүүлэх асуудлын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох үүднээс “Агнуурын байршил нутгийг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ын төслийг боловсруулав.

Тариалангийн газрын 1 га-гийн нөхөн сэргээлтийн зардлын норм, Газар нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх журам, 2002 онд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, бэлчээрийн талбайн хэмжээ, зардлын хуваарийг боловсруулж, батлуулав.

Байгаль орчны сайдын БНХАУ-д хийсэн айлчлал, Япон Улсын Загас, ой, усны нөөцийн яамны сайдын зөвлөх Моримотогийн Монгол дахь айлчлалыг тус тус зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тогтоов.

Ойн үндэсний хөтөлбөрийг дэмжих төслийн гэрээг ДХХБ-тай хийв. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн хавсралтад Монгол Улсаас шинээр оруулах 4 зүйлийн хөхтөн, 5 зүйлийн шувуудын тухай дэлгэрэнгүй материалыг бэлтгэж конвенцийн НБДГ-т хүргүүлэв.

Ази-Номхон далайн орнуудын ойн комиссын XIX чуулганыг зохион байгуулах тухай асуудлаар ДХХБ-тай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Мод, модон материалын зөрчилтэй тэмцэх хяналт шалгалтын график гарган мөрдөж ашиглаж байна. Хяналт шалгалтаар тээврийн зөрчилтэй 16 хэрэгсэлд ачсан 225 ширхэг нойтон нарсан дүнг, 105 ширхэг хуурай нарсан дүнгийг хураагаад байна. Мөн гарал үүслийн гэрчилгээ болон бусад бичиг баримтын зөрчилтэй буруутай 6 этгээдэд 90000 төгрөгийн торгууль ногдуулав.

Хяналтын пост бариулах хөрөнгийг шийдвэрлүүлж Баянзүрх, 7-н буудлын хяналтын постын барилгын өрлөгийг эхэлсэн, 22-ын товчооны барилгыг эхлэхэд бэлэн болгоод байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр 2002 оны 4 дүгээр сарын 15-нд УЦУОШГ-ын үйл ажиллагаатай танилцав. Ерөнхий сайд УЦУОШГ болон түүний харьяа мэргэжлийн байгууллагуудаар орж, тэдний өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын байрны онцлог, гаргаж байгаа мэдээллийг үзэж сонирхов. Ерөнхий сайд ажилчидтай уулзалт зохион байгуулж ус цаг уур, байгаль орчны талаар санал бодлоо илэрхийлж үг хэлэв. Энэ хавар болж байгаа цаг агаарын гамшигт үзэгдлийг урьдаас зөв тодорхойлж ард иргэдийг сэрэмжлүүлэх талаар санаачлагатай ажилласнаар учирч болох хор хохирлыг бууруулж чадсаныг Ерөнхий сайд сайшаан тэмдэглэв.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

“Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барих гэж байна.

Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хооронд “Батлан хамгаалах аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг Засгийн газраар батламжлуулж, “Цэргийн тусламж үзүүлэх хэлэлцээр”-т Засгийн газрыг төлөөлөн гарын үсэг зурах эрх авах асуудлаар Засгийн газрын шийдвэр гаргуулав.

“Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Зэвсэгт хүчний тухай хууль”-ийн төслийг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцүүлэв.

Зэвсэгт хүчний сургалт, бэлтгэл, бэлэн байдлын талаар

“Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Зэвсэгт хүчний зарим нэгтгэл ангиудын ТЦОТ-ны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж, ЗХЕШ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна.

Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн химийн зэвсэглэл, хамгаалах хэрэгсэлд цогцолбор тооллого хийж, химийн эд хэрэгсэл, бодис уусмалын чанар байдалд лабораторийн шинжилгээ хийлгэж, тус ангид цэвэрлэгээний “РД” уусмалыг татан авч, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулав.

Нэгтгэл ангиудын байлдааны жижүүрлэлтийн ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлж, 2671 онгоцонд радиолокацийн болон диспетчерийн хяналт тавьснаас 2503 нь олон улсын, 168 нь орон нутгийн нислэг байлаа.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын цэргийн сургалт бэлтгэлийн явц, үр дүнг шалгах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдөж эхэллээ.

Зэвсэгт хүчний холбоочдын тусгай тактикийн хээрийн сургуулийг нийт 456 хүн, 122 авто болон холбооны техник хэрэгслийг хамруулан зохион байгуулав. Хээрийн сургуулийн холбооны суурин зангилгааг “Орхон”-оос 96 км-т дэлгэн байгуулсан. ЗХЕШ-ын командын байрны холбооны хөдөлгөөнт зангилгаатай радио релейний станцаар нягтруулсан сувгийг үүсгэн түүнийгээ өөрсдийн мэргэжилтнүүдийн хийсэн Dial-Up модем ашиглан тоон

системд хувиргаж, командын байр дээр байгуулав. 4-5 хэрэглэгчтэй компьютерийн хөдөлгөөнт сүлжээтэй холбон, ЗХЕШ-ын мэдээллийн дотоод сүлжээгээр дамжуулан хэрэглэгчтэй болон хамгаалагдсан командын байрны холбооны зангилгаатай мэдээлэл солилцох туршилт хийсэн нь мэдээлэл дамжуулах хурд 4800-28500 бит/сек хүрч, ердийн телеграфын тэмдэгт дамжуулах хурднаас 60 дахин нэмэгдэх боломжтой болохыг туршин тогтоосон нь чухал боллоо.

Зэвсэгт хүчний хэмжээнд 2002 оны IV сарын 20-ны байдлаар 4965156.4 мянган төгрөг улсын төсвөөс авах ёстойгоос 3998958.0 төгрөг буюу дээрх төсвийн 80.5 хувийг авч нэгтгэл, ангиудад хуваарилж 966171.4 мянган төгрөгийн дутуу санхүүжилттэй байна.

2002-2003 оны хаврын тариалалтын 69.5 сая төгрөгийн санхүүжилтийг нэгтгэл, ангиудад бүрэн хийж дуусгалаа.

Барилгын цэрэг өнгөрсөн сард 160.0 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж, төлөвлөгөөг 105.1 хувь, 5.0 сач төгрөгийн барилгын материал, хийц үйлдвэрлэж, төлөвлөгөөг 40 хувь, 80.0 мянган тн/км-ийн ачаа эргэлтийн үүрэг гүйцэтгэж, төлөвлөгөөг 57 хувиар биелүүлээд байна.

Иргэний хамгаалалт, байгалийн гамшиг, ослын цагийн байдлын талаар

“Гамшгийн аюулаас хамгаалах тухай” хуулийн төслийг шинэчлэн боловсруулаад байна.

Улсын Иргэний хамгаалалтын газраас ой, хээрийн түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай албан тоотыг аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэний хамгаалалтын дарга нарт хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

IV сард Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Дундговь аймгуудын нутгаар болсон 28-32 м/сек-ийн хүчтэй цасан ба шороон шуурганы улмаас 7 хүний амь нас эрсдэж, 7400 мал хорогдсон, 32000 мал уруудаж, 11 гэр унаж, 58 хашаа нурж, 1 байшингийн дээвэр хуурч өндөр хүчдлийн 7 шон хугарч их хэмжээний хохирол учрууллаа.

УИХГ, Ус, цаг уурын орчны шинжилгээний төвтэй хамтран аймгуудын Цэрэг-иргэний хамгаалалтын штаб, орон нутгийн удирдлагатай радио хурал зохион байгуулан гамшгийн аюулт үзэгдлийн тухай урьдчилан мэдээлж, иргэний хамгаалалтын мэргэжлийн алба, штаб, шуурхай бүлгүүдийг бэлэн байдалд оруулан шуурхай ажилласнаар салхинд уруудан алга болсон 15 хүнийг эрж олоод байна.

Орон нутагт гарсан ой хээрийн түймрийг унтраах ажлыг зохион байгууллаа.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Бага, дунд боловсролын талаар

Монгол Улсын Бүх нийтийн боловсролын Үндэсний Форум байгуулах хуралдаан болон Бүх нийтийн боловсролын Үндэсний Форумын I хуралдааныг Албан бус боловсролын төв, НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газруудтай хамтран зохион байгууллаа.

- *Хуралдаанаар Монгол Улсын Бүх нийтийн боловсролын үндэсний форумын дүрмийг батлан, Форумыг 26 гишүүн байгууллага, нарийн бичгийн газар, ажлын хэсгүүд болон мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжтэйгээр байгуулж, Форумын даргаар БСШУ-ны сайд А.Цанжид, Форумын зохицуулагчаар БСШУЯ-ны Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын газрын орлогч дарга Ц.Мягмарыг тус тус сонголоо.*
- *Монголын бүх нийтийн боловсролыг 2002-2005 онуудад хөгжүүлэх дунд шатны төлөвлөгөөг хэлэлцэж, гишүүн байгууллагууд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ямар чиг үүрэгтэй оролцохоо ярилцсан бөгөөд энэ нь бүх нийтийн суурь боловсролын салбарт үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжсэн хэлэлцүүлэг боллоо.*

“Анги удирдсан багш нарын зөвлөгөөн” зохион байгуулж, 710 төлөөлөгч оролцов.

Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Үндэсний зохицуулах зөвлөл”-ийг байгуулав.

“Хөдөөгийн бага насны хүүхдийг гэр бүлд тулгуурлан хөгжүүлэх нь” төслийг дахин боловсруулж, ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газарт өргөн барьж, уг төсөлд ЮНЕСКО-гоос 2002 онд санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулж, баталгаажуулсан бөгөөд төслийн баг ажлаа хэрэгжүүлж эхлээд байна. Уг төслийг “Хөдөөгийн иргэдэд соёл, боловсролын үйлчилгээг хүргэх нь” (Нүүдлийн соёлын төв) төслийн боловсролын хэсгийн агуулгад нэгтгэн оруулах талаар ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцан тохиролцоод байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгчийн газартай хамтран 2002-2003 онд суурь боловсролын салбарт “Хот суурин газрын боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх нь”, “Эмзэг бүлгийн хүүхдүүдэд боловсрол олгох нь”, “Хүүхдэд ээлтэй орчин”, “Хөдөө, орон нутгийн сургуулийн халаалтын системийг сайжруулах нь” төслүүд хэрэгжүүлэхээр тохироод байна. Үүнээс гадна хөдөө, орон нутгийн 32 сургуулийн хичээлийн болон дотуур байр засварлах хүсэлтийг НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгчийн газарт тавьсан бөгөөд хандивлагч орнуудад тавихаар НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгчийн газартай хамтран төсөл боловсруулж эхлээд байна.

Нийслэлийн 6 дүүргийн 12 ерөнхий боловсролын дунд сургуулийн 10 дугаар ангийн сурагчдаас өнгөрсөн жилийн улсын шалгалтын математик, хими, монгол хэл, физикийн хичээлийн тестээр төвшин тогтоох шалгалт авч дүнг гаргалаа. Шалгалтын дүнгээс үзэхэд улсын шалгалтын бэлтгэл маш хангалтгүй байна.

Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар

Мэдээллийн технологийн инкубатор байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулав.

2002 онд ШУТС-гийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх ШУТ-ийн зэхэц ажлыг сонгон шалгаруулах комиссыг байгуулав. БСШУЯ-наас гаргасан загварын дагуу зэхэц ажлын саналуудыг эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудаас хүлээн авч, нийт 20 гаруй ажлыг хэлэлцүүлэгт оруулан, 9 ажлыг сонгон шалгаруулаад байна.

Археологийн хүрээлэн, Алмааз болон үнэт металлын хүрээлэн, Каках-Монгол судлалын төв байгуулах тухай асуудлыг БСШУ-ны Сайдын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэв. Уг хурлаас Археологийн хүрээлэн байгуулах асуудлыг дэмжиж, яамдаас санал авч Засгийн газарт оруулах, Алмааз болон үнэт металлын хүрээлэнгийн асуудлыг хойшлуулж, харин төсөл хэлбэрээр санхүүжүүлж, боловсон хүчин ба материаллаг баазтай болоход нь дэмжлэг үзүүлэх талаар ШУА-д чиглэл өгөх, Каках-Монгол судлалын төв байгуулах тухайд Баян-Өлгий аймгийн Засаг дарга болон тус аймгийн төв дахь Нийгэм-эдийн засгийн судалгааны төвөөс тус тус санал авах нь зүйтэй гэж үзлээ.

Соёл, урлагийн талаар

“Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулав.

“Номын сангийн автоматжуулалт” сургалтыг зохион байгуулав. Сургалтанд нийтийн болон их, дээд сургуулийн 35 номын санчид хамрагдлаа.

“Номын сангийн автоматжуулалт-WINISIS”, “Номын сангийн заах арга зүйн ажил”, “Номын сан, мэдээллийн байгууллагын маркетинг” номуудыг хэвлэлтэд шилжүүлэв.

ОХУ-ын Соёлын яамны төлөөлөгчдийг хүлээн авч “Соёл, урлагийн салбарт хамтран ажиллах гэрээ”-ний төсөл дээр хамтран ажиллав.

БНАСАУ-д зохиогдсон “Хаврын баяр” урлагийн наадамд монголын төлөөлөгчид амжилттай оролцож нийт 13 шагнал хүртэв.

Билгэ хаан, Культегиний хөшөө, хар балгас, Төвхөн хийд, Тоньюкукийн хөшөөний хамгаалалтын бүсийг тогтоох асуудлыг Засгийн газрын 4 сарын 17-ны хуралдаанаар хэлэлцүүлэн 71-р тогтоолоор батлуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын зөвлөлийн хуралдаанаар “Хөдөө орон нутагт дутагдаж байгаа багш, хүний эмч нарыг бэлтгэх, тэдэнд хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын төсөл, Зарим их сургууль, коллежид шинэ мэргэжил нээх тухай, Шинжлэх ухааны зарим хүрээлэн байгуулах тухай, “Шилдэг оюутан шалгаруулах журам”-ын төсөл,

“Шилдэг оюутны анхан шатны байгууллага шалгаруулах журам”-ын төсөл, Бага, дунд боловсролын стандартыг шинэчлэх үзэл баримтлалын тухай зэрэг асуудлыг хэлэлцэж зохих шийдвэр гаргав.

“Монгол Улсын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хооронд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээр”-ийн төслийн талаар холбогдох яам, газруудын саналыг авч, Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэр гаргуулав. Одоо хоёр тал уг хэлэлцээрт гарын үсэг зурахад бэлэн болоод байна.

“Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд шинжлэх ухаан, соёлын салбарт 2002-2005 онд хамтран ажиллах Хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцэх зөвлөлдөх-уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын үр дүнд хоёр орны Засгийн газар хооронд шинжлэх ухаан, соёлын салбарт 2002-2005 онд хамтран ажиллах Хөтөлбөрийн талаар харилцан санал солилцож Засгийн газрын хуралдаанаар шийдвэр гаргуулахаар тохиролцов.

БНСУ-тай боловсролын салбарт 2002-2005 онд хамтрэн ажиллах хөтөлбөрийг эцэслэн тохиров.

Соёл, урлагийн салбарын ажиллагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах санал боловсруулах болсонтой холбогдуулан салбарын ҮЭ-ийн холбоотой хамтран төвийн соёл, урлагийн байгууллагуудын нягтлан бодогч нарт семинар өгч, ажиллагчдын цалин, нэмэгдэл, орон тооны судалгаа гаргах ажлыг эхлүүлээд байна.

ДЭД БҮТЦИЙН ЯАМ

Түлш, эрчим хүчний хандивлагчдын зөвлөгөөнийг зохион байгуулав.

Шингэрүүлсэн шатдаг хий боловсруулах үйлдвэр барих талаар “Востокнефтьгаз” ХХК, Нүүрсний газрын хооронд хамтран ажиллах тухай протокол байгуулав. Улсын томоохон хотуудад шингэрүүлсэн шатдаг хийн агуулах, станц байгуулах болон хэрэглэгчдийг хийгээр хангах, зах зээлийг өргөжүүлэх, аюулгүй байдлыг хангах талаар “Востокнефтьгаз” ХХК, Петровис ХХК, Газ сервис” ХХК, “Мон-Газ” ХХК зэрэг компаниудтай техникийн зөвлөгөөн зохион байгуулав.

Барилгын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж, батлуулав. Ингэснээр барилга, барилгын материалын салбарыг ойрын ирээдүйд хөгжүүлэх үндсэн зорилтууд тогтоогдлоо.

Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барив. Хууль батлагдсанаар хэрэглэгч-хангагч нарын харилцаа хуулиар зохицуулагдаж, улмаар хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг арилгах, багасгах боломж бүрдэнэ.

“Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх Үндэсний хөтөлбөр”, “Автотээврийн салбарын ажилтны цалин хөлс, хөдөлмөр нийгмийн хамгааллын талаар 2002-2003 онд зохицуулж хэрэгжүүлэхээр автотээврийн салбарын төрийн захиргаа, ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулах хамтын хэлэлцээр”-ийг боловсруулж шийдвэрлүүлэв.

Мянганы зам төслийг хэрэгжүүлэх, замын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор “Олон улс болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам”-ын төслийг боловсруулав.

“МИАТ” ХК-ийн олон улсын нислэгийн онгоцыг шинэчлэх чиглэлээр АНУ-ын Сан Франциско хотод тус улсын санхүү түрээсийн GATX компанийн төлөөлөгчидтэй В737-800 онгоцыг ашиглалтын лизингээр авч ашиглахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирч гарын үсэг зурлаа.

НҮБ-ын Түмэн бүс хөтөлбөрийн хүрээнд УБ хотноо “Түмэн бүс хөтөлбөрийн харилцаа, холбооны салбарын ажлын хэсгийн I уулзалтыг зохион байгуулав. Уулзалтаар цаашид салбарын хэмжээнд гишүүн орнууд хамтран ажиллах тэргүүлэх чиглэл, ажлын

хэсгийн 2002 оны төлөвлөгөө, ажлын хэсгийн техникийн даалгавар, бодлого болон зохицуулалт, сүлжээний харилцан холбогдох асуудал хэлэлцэж, судалгааны төслүүд зэргийг тохиролцов.

Мэдээлэл, холбооны технологийн бодлого, зохицуулалтын оновчтой институци байгуулах, механизм бүрдүүлэх талаар санал боловсруулж “Дэд бүтцийн яаманд МХТ-ийн бодлого, зохицуулалтын газар байгуулах хувилбар дээр санал тогтов.

УБ хотын аялал жуулчлалын Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Монгол Улс, БНЭУ-тай аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын салбар дахь харилцааг идэвхжүүлэх зорилгоор Монгол-Энэтхэгийн талын хамтарсан ажлын хэсгийн Монголын талын ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.

Сумдын төвийн цахилгаан станцыг шинэчлэх төслийн IV шатны II хэсгийн Завхан, Ховд аймгийн сумдад нийлүүлэх дизель цахилгаан станц, нам хүчдэлийн цахилгааны самбарын үйлдвэрийн туршилтыг зохион байгуулав.

Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа УБ хотын авто замыг сайжруулах төслийн барилгын ажлын нээлтийг зохион байгуулав.

БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Хөдөөгийн цахилгаан холбоо-МОН-4” төслийн нээлтийн ажиллагааг хийлээ. БНСУ-ын Засгийн газраас олгож буй 1.0 сая ам.долларын тусламжийн хүрээнд Монгол Улсад “Мэдээлийн технологийн парк” байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж, “Мэдээллийн технологийн парк” байгуулах эхний шатны ажлыг гүйцэтгэлээ.

Архангай, Булган, Баян-Өлгий аймгийн зарим багт шинээр суурилуулах радио станцуудыг орон нутагт ачуулж, Архангай аймгийн Хашаат сумын 3 багаас бусдад нь суурилуулж ашиглалтанд хүлээлгэж өгөөд байна.

Монгол-Вьетнамын ЗГХК-ын Х хуралдаан болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сингапур Улсад хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргав. Сингапур Улстай дэд бүтцийн салбарт хамтран ажиллах саналыг боловсруулж, Сингапурт суугаа худалдааны төлөөлөгчид хүргүүлэв.

Монгол-Герман, Монгол-Чехийн Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаануудад бэлтгэх монголын хэсгийн төлөөлөгчдийг томилон оролцуулж, дэд бүтцийн салбарт тухайн улсуудтай хамтран ажиллах саналыг боловсрууллаа.

БНСУ-ын КОЙКА байгууллагаас 2003 онд буцалтгүй тусламжийн хүрээнд дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслүүдийн жагсаалтыг нэгтгэн гаргав.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ

Нийгмийн хамгааллын талаар:

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай”, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай”, “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай”, “Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай” хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл, баримтлалын төслийг боловсруулаад байна. Хуулийн төслүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан заалтуудыг өөрчлөхөөр тусгасан болно.

Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн нарт нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай Засгийн газрын тогтоол гарав. Уг тогтоолоор Монгол Улсын баатарт-500000, Хөдөлмөрийн баатарт-450000, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд-250000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэсэн болно.

Насжилтийн асуудлаарх дэлхийн II чуулга уулзалтанд НХХ-ийн сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Чуулганд Сайд Ши.Батбаяр “Монголын ахмадын өнөөгийн байдал, цаашад авах арга хэмжээ”- ний тухай үг хэлэв.

Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжих “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” төслийн баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд АХБ, НХХЯ хамтран уулзалт ярилцлагыг зохион байгуулж бодлого

боловсруулагчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, төрийн бус байгууллагын чадавхийг тодорхойлсон судалгааны дүнг хэлэлцэв.

Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс төрийн байгууллагын зарим үүргийг гүйцэтгэх талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай 2002 онд байгуулах гэрээний төслийг боловсруулж сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Гэрээнд МХЭАХН-ээр хэрэглэгчтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэхэд оролцох, биелэлтэнд хяналт тавих, хэрэглэгчдийн дулаан, ус телефон ашиглалтанд судалгаа тооцоо хийж, хэрэгжүүлэх үүргийг тусгав.

Хүн амын бодлого, стратеги төлөвлөлтийн талаар авсан арга хэмжээ

Орон сууцны хөтөлбөр, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт, Орон сууц хөгжүүлэх, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам, Орон сууц хөгжүүлэх сангаас зээл олгох журмын төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар батлуулав. Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийг боловсруулж, шаардагдах хөрөнгийн тооцоог хийж байна.

Ерөнхий сайдын ХБНГУ-д айлчлах үеэр НХХЯ, ХБНГУ-ын гэр бүл, ахмад, эмэгтэйчүүд, залуучуудын яамны хооронд Залуучуудын асуудлаар 2002-2004 онуудад хамтран ажиллах тухай мэдэгдэлд хоёр тал гарын үсэг зурав. ХБНГУ-ын гэр бүл, ахмад, эмэгтэйчүүд, залуучуудын яам, Нийслэлийн ЗДТГазартай хамтран хэрэгжүүлэх УБ хотын дүүрэг, хороодын залуучуудын асуудал хариуцсан ажилтнуудыг сургах төслийг Дарь-Эхийн хорооллыг хөгжүүлэх хотын хөгжлийн бодлоготой уялдуулан “Залуучуудын асуудал эрхэлсэн ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэх, залуучуудын талаарх мэдээллийг хөгжүүлэх нь” төслийн саналыг боловсруулаад байна. Урьдчилсан байдлаар төслийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхэд жил бүр 4500 евро-г зарцуулахаар Германы тал шийдвэрлээд байна.

Монгол Улсын НХХЯ, БНСУ-ын Соёл, аялал жуучлалын яамны хооронд залуучуудын асуудлаар хамтран ажиллах тохиролцооны дагуу БНСУ-ын Сеүл хотноо Монголын залуучуудын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтнууд, оюутан, сурагчдын төлөөлөгчид айлчилж, Солонгос орны хөгжил, соёл урлаг, түүх, хүүхэд залуучуудын амьдралтай танилцсанаас гадна Монгол орны хөгжил, залуучуудын амьдралын талаар танилцуулан мэдээлэл, сурталчилгааг хийж соёл-урлаг спортын тэмцээн, нөхөрсөг уулзалтуудад оролцсон.

2002 оныг “Оюутны жил” болгон зарласантай уялдуулан оюутны нийгмийн даатгалыг сургалтын төлбөрт оруулах, албан бус сургалт явуулах төв байгуулах, хөдөлмөр эрхлэх зуучлалын алба ажиллуулах, тэднийг хөдөлмөрийн багтаамж ихтэй нийтийг хамарсан ажилд оролцуулах зэрэг 24 асуудлыг тусган батлуулж, холбогдох газар, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн төслийг дахин хянан боловсруулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас “Жижиг зээл олгох үйл ажиллагааг банк, ББСБ-аар дамжуулан гүйцэтгүүлэх гэрээний загвар”-ыг сайдын тушаалаар батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Монгол Улсын иргэд, БНЧУ-ын иргэдийг харилцан хөдөлмөр эрхлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНЧУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулав.

1999-2001 онуудад зудын гамшигт малгүй болсон буюу малаа их хэмжээгээр хорогдуулсан малчдын судалгааг 14 аймгийн дүнгээр гарган нэгтгэв.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг эцэслэн боловсруулав.

Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн талаар иргэд хөдөлмөрчдөөс дээд шатны байгууллага, УИХ-ын гишүүдэд ирүүлж байгаа өргөдөл хүсэлтийн дагуу Дархан-

Уул аймаг, Шарынгол хотуудад ажиллаж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болсон иргэдэд нөхөн олговрыг олгуулах ажлыг шийдвэрлэв.

Гадаад хамтын ажиллагааны талаар:

ХБНГУ-ын Холбооны Гэр бүл, ахмадууд, эмэгтэйчүүд, залуучуудын яамтай залуучуудын бодлогын талаар хамтран ажиллах тухай хамтарсан Мэдэгдлийн хугацааг сунгаж Монгол Улсын Ерөнхий сайд ХБНГУ-д хийх ажлын айлчлалын үеэр Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайд Б.Баярсайхан гарын үсэг зурах бэлтгэл ажлыг ГХЯ-тай хамтран гүйцэтгэв.

Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Сайд Ши.Батбаяр шинээр томилогдсон НҮБ –ын хүүхдийн сангийн Суурин төлөөлөгч ноён Ричард Прадог хүлээж авч уулзан, Нью Йоркт болох Хүүхдийн асуудлаарх НҮБ-ын тусгай чуулганы бэлтгэл ажил, Монголын хүүхэд өсвөр үеийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, хүүхдийн хамгааллын асуудлуудын талаар харилцан санал солилцов.

Тэрчлэн Солонгост ажиллахаар мөнгөө өгч залилуулсан иргэдийн асуудлаар яамны байр суурийг илэрхийлсэнхэвлэлийн албаны мэдэгдэл ярилцлага, тодруулга, тайлбарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж сурталчлав.

2002 оны IV сарын 1-ний байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд 13575,6 сая төгрөгийн шимтгэл, хураамжийн орлого хуримтлуулахаас 16458,1 сая төгрөг төвлөрүүлж , орлогын төлөвлөгөөг 121,2 хувиар биелүүлж байна.

Үүнээс тэтгэврийн даатгалын санд оны эхнээс өссөн дүнгээр шимтгэл хураамжийн орлого 10608,1 сая төгрөг, төсвийн татаасаар 600,0 сая төгрөг, нийт 11208,1 сая төгрөг хуримтлагдсан байна.

2002 оны IV сарын 1-ний байдлаар тэтгэвэрт зориулан олгох 15682,5 сая төгрөгийг бүх аймаг, нийслэлийн дүүргүүдэд олгосон.

Нийгмийн халамжийн санд IV сарын 1-ний байдлаар 1187,0 сая төгрөгийн төсвийн санхүүжилт авч 30991 хүнд 327,9 сая төгрөгийн тэтгэвэр, 38909 хүнд 693,1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Оны эхний 3 сарын байдлаар 3284 хүнд 38,9 сая төгрөгийн тэтгэвэр, 6504 хүнд 138,9 сая төгрөгийн халамжийн тэтгэмж олгогдоогүй байна.

2002 оны 4 дүгээр сарын 1-ний байдлаар Нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн авлага 10819,3 сая төгрөг, үүнээс 9296,5 сая төгрөг нь аж ахуйн нэгж байгууллагаас, 1522,8 сая төгрөг нь төсвийн байгууллагаас авах авлалга байна. Өмнөх 2 сарын дүнтэй харьцуулбал авах авлагын хэмжээ бага зэрэг буурах хандлагатай байна.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ЯАМ

Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын талаар:

Татварын таатай орчин бүрдүүлэх талаар заасан арга хэмжээг хэрэгжүүлэх Үйлдвэр, худалдааны сайдын тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах сайдын тушаалыг боловсруулж батлуулав.

Импортын гаалийн татварын хувь хэмжээг тогтоох тухай УИХ-ын 51 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл боловсрууллаа.

Модны чиглэлээр “Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг Сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэв.

“Ой мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний асуудлыг УИХ-ын БОХХБХ-ны өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж тогтоол гаргуулав.

“Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний асуудлыг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гарсан шийдвэрийг Зөвлөлийн гишүүдэд хүргүүлэв.

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

Хуудас 12

Шингэрүүлсэн шатдаг хий, нефть бүтээгдэхүүнээр хэсэгчлэн хангах “Монгол Улсад хийн салбарыг хөгжүүлэх, хамтран ажиллах тухай” Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийн төсөлд санал өгөв.

“Хөтөлийн “Ган” үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал бэлтгэв.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуульд нийцүүлэн Одон, медаль болон тамга, тэмдэг, үнэт металл, эрдэнийн чулуун эдлэлийн үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрлийн журмын төсөл боловсруулав.

“Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах асуудлыг бэлтгэж яамдаас санал авч байна.

Арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх талаар “Харгиа” компанитай хамтран судалгааг хийж, шинэчлэлтийн төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийн талаар санал боловсруулж Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэв.

Геологи, эрдэс баялгийн бодлого, зохицуулалтын талаар:

Улсын төсвийн хөрөнгөөр 2002 онд шинээр эхлүүлэх геологийн судалгааны 12 төслийн гүйцэтгэгчийг сонгох тендерийг шалгаруулан Тендерийн хорооны зөвлөмж гаргаж, шалгарсан компаниудтай гэрээ хийж байна.

Геологи, уул уурхайн салбарын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, “Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль”-ийн төслийг боловсруулаад байна.

Асгатын мөнгөний ордыг хамтран ашиглах талаар ОХУ-ын Алтайн бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчтэй санамж бичиг үйлдэв.

“УБ хот орчмын нутаг дэвсгэрийн геоэкологийн үнэлгээ” төслөөр санал бэлтгэж, ШУТС-аас 2003 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтанд орууллаа.

2003-2005 оны Геологи, уул уурхайн салбарт улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гаргаж байна.

Худалдааны бодлого, зохицуулалтын талаар:

Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 35 дугаар тогтоолын дагуу яам, түүний харьяа агентлагуудын хүрээнд мөрдөж байгаа эрхийн актуудын жагсаалт гаргаж хянан үзэж хүчингүй болгох, стандарт боловсруулах болон шинэчлэх шаардлагатай эрхийн актын жагсаалт гаргах, Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх хорт бодис худалдаалах болон тэсэрч дэлбэрэх бодис худалдаалах тусгай зөвшөөрөл олгох журмын төсөл боловсруулж байна.

Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээ олгох, түүнийг баталгаажуулах журмын шинэчилсэн төслийн тухай асуудлыг Үйлдвэр, худалдааны сайдын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэн, түүнийг холбогдох яамдын сайд нарын тушаалаар баталж мөрдүүлэх чиглэл авав.

Гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх бодлого, “Гадаад худалдааны үзэл баримтлал” боловсруулах бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Уг төлөвлөгөөний хүрээнд Экспортыг дэмжих хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж байна.

Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн тухай хуулийн төслийг шинэчлэн найруулж, УИХ-д өргөн барихад бэлэн болгов.

Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөр, Экспортыг дэмжих сангийн зарим арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвт тусгагдсан 200,0 сая төгрөгийн дэлгэрэнгүй төсвийг боловсруулж Санхүү эдийн засаг, Үйлдвэр, худалдааны сайд нарын хамтарсан тушаалаар батлуулж хэрэгжүүлж эхлэх ажилд оров.

Шатахуун түгээгүүрийн станцын галын аюулгүй байдлын дүрмийг ХЗДХЯ-аар батлуулж орон даяар хэрэгжүүлж эхлэв.

Хойт Америк-Монголын бизнесийн зөвлөлийн ерөнхийлөгч С.Сандерсийг Үйлдвэр, худалдааны сайд хүлээн авч уулзав. Уулзалтаар энэ оны VI сард УБ-т зохиох Хойт

Америк-Монголын хөрөнгө оруулалтын дугуй ширээний ярилцлага, түүний урьдчилсан хөтөлбөр, бэлтгэх асуудал, Монголын талаас хийх мэдээлэл, энэ чиглэлээр хамтран ажиллах болон Монгол-Америкийн хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар санал солилцов.

Япон улсад 2005 онд зохиогдох ЭКСПО-2005 үзэсгэлэнд Монгол Улс оролцох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэв. Энэ тухай Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдад захидлаар мэдэгдэв.

Хятадын тал “Эрдэнэт” үйлдвэрийн зэсийн баяжмалын худалдааг шууд хийх тухай санал тавьсантай холбогдуулан БНХАУ-ын ЭСЯ-ны Худалдаа, эдийн засгийн зөвлөхийг ҮХЯ-ны удирдлагуудтай уулзуулав.

Голланд-Монголын хамтарсан эрчим хүчний ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих зорилго бүхий “NEW 21” төслийн удирдах зөвлөлийн хурлаар төслийн хүрээнд эхний I улиралд хийсэн ажил, БНХАУ-д төсөл хэрэгжүүлсэн байдалтай танилцаж туршлага судалсан дүнг хэлэлцэхэд оролцов.

Монгол-Европын холбооны хамтын ажиллагааны Дэд хорооны ээлжит хурлын үеэр ЕХ-нд тавих асуудлаар санал бэлтгэж Тасис хөтөлбөрийн төлөөлөгчийн газарт мэдэгдэв. ЕХ-ны зах зээлд Монголын экспортыг нэмэгдүүлэх боломжийн талаар судалгаа хийж танилцуулга бэлтгэв.

“Монгол Улсад үр ашигтай худалдаа өргөжүүлэх сүлжээ байгуулах бэлтгэл ажилд туслах төсөл”-ийн шугамаар Олон улсын худалдааны төвөөс ирсэн төлөөлөгч Ш.Жанг-тай ажиллаж цаашдын ажлын чиглэлийг ярилцан тодорхойлж бусад байгууллагатай хийх уулзалтыг зохион байгуулав.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

Мал үржлийн албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох болон “Шилмэл хээлтүүлэгч” дэд хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Улсын нөөцийн тухай” хууль болон “Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, “Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр оруулах, гаргах, хорио цээрийн хяналт, шалгалтын тухай”, “Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.

Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт, паразиттах өвчнийг оношлох лабораторийн шинжилгээ, эм биобэлдмэлийг шалгах, ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээний жагсаалтын төсөл болон түүнийг батлах тухай төсөл боловсруулж, СЭЗЯ-нд хүргүүлэв.

“Малын эмчид итгэмжлэл олгох журам”, “Мал эмнэлгийн магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүн”, “Итгэмжлэлийн гэрчилгээний загвар”-ын төсөл боловсруулан, батлуулав.

ХХАА-н сайд ОХУ-ын Засгийн газрын дарга Монголд хийсэн айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ирсэн БНАлтай Улсын тэргүүн, Засгийн гарын дарга М.И.Лапшин, БНТува Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын дарга Ш.Д.Оржак, ОХУ-ын Мал эмнэлгийн газрын дэд захирал В.В.Селиверстов нарыг хүлээн авч уулзан, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

НҮБ-ын ХААХОСангийн хөнгөлөлттэй зээлээр 2003 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа “Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр” төслийн баримт бичгийг эцэслэн боловсруулав.

“Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын үйл ажиллагааны хөтөлбөрийг оновчтой болгох нь” бодлогын баримт бичигт цаашид ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих, салбарын мэргэжилтнүүдийг сургах чиглэлээр хамтран ажиллах тухай санал боловсруулав.

ХХАА-н сайд Итали Улсын Бээжин дэх Элчин сайдын яамны I нарийн бичгийн даргыг өөрийн хүсэлтийн дагуу хүлээн авч уулзан, хамтын ажиллагааны талаар ярилцав.

“Хувьчлагдсан мал эмнэлгийг дэмжих төслийн явцад Германы талаас үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулж, 2 дахь шатны зорилтыг тодорхойлох Санамж бичигт гарын үсэг зурав.

Улсын төсвөөс 2002 онд худаг засварын ажилд зориулан олгосон 400.0 сая төгрөг, уст цэгийн хайгуулын ажилд 30.0 сая төгрөгийн орон нутагт зарцуулах тендерийн асуудлаар зөвлөмж боловсруулан аймгуудад хүргүүлэв.

ОХУ-аас үр авах 1.2 тэрбум төгрөгийг СЭЗЯ-наас авч ХААН банкинд аккредитив нээлгэн эхний ээлжийн 420.0 мянган долларыг шилжүүлэх, буудай ачиж ирүүлэх ажлыг зохицуулав.

Италийн Засгийн газрын буцалтгүй тусламжаар ирсэн буудайг борлуулах, Японы Засгийн газрын КР-1 төслийн тусламжийн улаан буудай борлуулах ажлыг үргэлжлүүлэн одоогийн байдлаар 16.6 мянган тн-ыг борлуулж, нийт 2.3 тэрбум төгрөгийн хуримтлал бий болгов.

Улсын нөөцөөс үр гаргах тухай Засгийн газрын 2002 оны 66 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2002 оны хаврын тариалалтад шаардагдах үрийг хуваарилах, олгох ажлыг Улсын нөөцийн газартай хамтран зохион байгуулж байна.

Үлийн цагаан оготнойтой хими, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг 7 аймгийн 29 сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж эхэлсэн бөгөөд энэ ажилд шаардагдах 900 тн өгөөшийг хугацаанд нь бэлтгүүлж хүргүүлэв.

“Ногоон хувьсгал” хөтөлбөрийн тендерээр нийлүүлэгдсэн 30 иж бүрдэл бага оврын трактор, 100 ш усалгааны тоног төхөөрөмж, 100 ш бага оврын хор шүршигч болон төмс, хүнсний ногооны үрийг хуваарилах, орон нутагт хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

“Төвлөрсөн хот суурин газруудад сүү, цагаан идээ худалдаалах үеийн мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн журам”-ыг эцэслэн боловсруулав.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

НҮБ-ын Хүн амын сангаас Монгол Улсад үзүүлэх тусламжийн III хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “НҮЭМ-ийн бодлого хөтөлбөрийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх” төслийн баримт бичигт Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа болон НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Линда Демерс нар гарын үсэг зурав. 2002-2006 онд Засгийн газраас НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлэх хамгийн том төсөл болох энэ төсөл нь 3,4 сая ам.долларын төсөвтэйгөөр батлагдлаа.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хүрээнд 57,1 сая төгрөгийн үнэ бүхий багийн бага эмч нарын 933 ш цүнхийг иж бүрдлийн хамт аймаг, сумдад хуваарилан олгов.

Тайландад 2001 онд зохиогдсон тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцож, медалт байранд шалгарсан 21 тамирчинд 38,3 сая төгрөгийн шагналыг олгов. 2002 онд спортын өндөр амжилт гаргасан тамирчдад нийт 44,3 сая төгрөгийн шагнал олгоод байна.

Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүн, дүрэм, журмыг баталж, эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох “Нэг цэгийн үйлчилгээний нэгж”-ийг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн Магадлан итгэмжлэл, лицензийн албаны бүтцэд 3-4 орон тоотойгоор зохион байгуулж ажиллуулахыг тус төвийн захиралд даалгав.

Архангайн Хашаат, Булганы Бүрэгхангай, Баянхонгорын нэгдсэн эмнэлэг, Дорноговийн Даланжаргалан, Дорнодын Цагаан-Овоо, Говь-Алтайн нэгдсэн эмнэлэг, Завханы нэгдсэн эмнэлэг болон Идэр, Өвөрхангайн Тарагт, Сүхбаатарын Буяндэлгэр, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг, Төвийн Аргалант, Хэнтийн Баянхутаг, Ховдын Манхан, Увсын нэгдсэн эмнэлэг, Сүхбаатарын нэгдсэн эмнэлэгт УАЗ-31512 автомашиныг тус тус олгож, 4 автомашиныг улсын нөөцөд, НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл

мэндийн дэд хөтөлбөр"-ийн шугамаар Хөвсгөлийн Улаан-Уул, Хэнтийн Баян-Адрага сумдад УАЗ-31512 автомашин, Баян-Өлгийн Цэнгэл, Дундговийн Дэлгэрхангай, Сүхбаатарын Түвшинширээ, Төвийн Угтаалцайдам, Увсын Наранбулаг, Сэлэнгийн Хүдэр сумдад ЗИД-200 маркийн мотоцикл тус бүр нэгийг өгөв.

“Сувилахуйн шинэ зуунд” сувилагч нарын I чуулга уулзалтыг зохион байгуулж, хот, хөдөөгийн 1400 гаруй сувилагчийг хамруулав.

“Хөдөлгөөн-эрүүл мэнд” сарын ажлыг зохион байгуулж, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах, дасгал заах зэрэг ажлыг зохион байгуулав. Дэлхийн эрүүл мэндийн өдрийг “Хөдөлгөөн-эрүүл мэнд” уриан дор зохион байгуулж, Эрүүл мэндийн болон спортын байгууллагуудын 400 гаруй төлөөлөгч оролцов.

Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Зохицуулах хороо”-г НҮБ-ын Хүүхдийн, ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газар, ЖАЙКА-гийн суурин төлөөлөгч, СЭЗЯ-ны төлөөллийг оролцуулан байгуулав. Дархлаажуулалтын асуудлаар олон улсын түншлэгч байгууллагуудтай харилцаж, Монгол Улсад нэвтрүүлэх болон шинэчилсэн схемээр хийх вакцины талаархи судалгааны явцыг сайдын зөвлөлд улирал тутам, дархлаажуулалтын асуудлаар жилийн болон 5 жилийн төлөвлөгөө, үндэслэл боловсруулж, сайдын зөвлөлд жил бүрийн II улиралд багтаан танилцуулж байхыг даалгав.

Бага насны хүүхдийн уушигны үрэвсэл, бактерт менингит өвчний үүсгэгчийн бүтцийг тодорхойлж, Hib вакциныг нэвтрүүлэх зорилгоор “Уушигны үрэвсэл, бактерт менингитийн үүсгэгчийн бүтцийг тодорхойлох талаар авах зарим арга хэмжээний тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалаар уушигны үрэвсэл, бактерт менингиттэй өвчтөнөөс эмнэлзүйн шинжлэгдэхүүн цуглуулах, хадгалах, зөөвөрлөх журам, уушигны үрэвсэл, бактерт менингитийн үүсгэгчийн бүтцийг тодорхойлох тандалт, судалгааны аргачллыг баталж, судалгааны ажлыг зохион байгуулах талаар холбогдох эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын дарга, ерөнхий эмч нар танилцуулав.

Сүрьеэ өвчинтэй тэмцэх Дэлхийн өдрийг “Сүрьеэ ба ядуурал” сэдвээр зохион байгуулав. Энэ арга хэмжээний хүрээнд сүрьеэгээс сэргийлэх талаар радио, телевизийн шууд ярилцлага нэвтрүүлгийг явуулав.

- 2002.04.01.-ний байдлаар Үндэсний зайлшгүй эмийн хангамж УБ хотод 88.7%, орон нутагт 72.5%-тай байна.
- 2002 оны IV сарын 1-ний байдлаар нийт 10624 эх амаржиж, 10605 амьд хүүхэд төрүүлж, 13 эх нас барсны 61.5% нь хөдөөд, 38.5% нь хотод байна.Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд төрсөн 1000 эх тутмын 1.22 нь эндэж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5 тохиолдлоор буурсан байна.
- 0-1 насны 375 хүүхэд эндсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.3 %-аар нэмэгджээ. Энэ үзүүлэлт Өмнөговь, Орхон, Ховд, Өвөрхангай, Дорнод, Говьсүмбэр, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл, Сүхбаатар, Баянхонгор, Дундговь, Сэлэнгэ аймгуудад улсын дунджаас өндөр байна.
- 5 хүртэлж насны хүүхдийн эндэгдлийн улсын дундаж үзүүлэлт өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.1%-аар нэмэгджээ. Говь-сүмбэр, Ховд, Өмнөговь, Завхан, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод, Баянхонгор, Баян-Өлгий, Дундговь аймгуудад улсын дунджаас өндөр байна.
- 2002 оны эхний 3 сард 10000 хүнд ногдох халдварт өвчин 40 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 17.6 %-аар ихэссэн байна. Халдварт өвчний улмаас 30 хүн нас барсан байна.

Яамдаас тухайн сард ирүүлсэн мэдээллийг үндэслэн нэгтгэж, бэлтгэсэн: шинжээч Д.Солонго